



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/151

Арвайхээр

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх,
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а” заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс 09 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд голомтын болон сэжигтэй бүс нутгийг хамруулж, мал эмнэлгийн мэргэжилтнүүдэд хүн хүчээр дэмжлэг үзүүлэхийг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын арга хэмжээг чанартай зохион байгуулахыг “ДС Дөхөм” мал эмнэлгийн малын их эмч (А.Батзаяа), “Үржин Дэвших” мал эмнэлгийн малын их эмч (Д.Бадамханд), “Баян сүргийн буян” мал эмнэлгийн малын их эмч (С.Эрдэнэбилэг), “Арвайн талын буян” мал эмнэлгийн малын их эмч (Б.Байгальмаа) нарт, үйл ажиллагаанд хяналт тавин ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Ё.Гэрэлт-Од)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАТ